**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Өмнөговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ӨМА-2025/001/НА-СТА-3ГТС

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br><br>Өмнөговь аймаг 2025 он | Өмнөговь дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр<br>Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn<br>Аудитын менежер: Т.Хонгорзул<br>Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Ж.Болормаа<br>Утас: 70533552 Цахим хаяг: bolormaaja@audit.gov.mn<br>Аудитор: Э.Жаргал<br>Утас: 70533552 Цахим хаяг: jargale@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2025.03.10 № 238

танай ________ -ны № ________ -т

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ДЭД САНГИЙН ДАРГА Б.ДОЛЖИНСҮРЭН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлийн 2024 оны 08 дугаар тогтоолоор "Ажил олгогчийг дэмжих туршилтын төсөл"-ийг хэрэгжүүлж эхлүүлэн 134,740.0 мянган төгрөгийн урамшууллыг 11 аж ахуйн нэгжид олгосон байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант хугацаанд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангаас 2,231,076.9 мянган төгрөгийн санхүүжилтийг 3254 иргэнд олгож 889 ажлын байр бий болгосон байна албан хаагчдад 207,375.6 мянган төгрөгийн орон нутгийн нэмэгдэл олгосон байна.

**Бусад асуудлын хэсэг**

4625020457
F:\2.Бичиг хэрэг\2025он\СТА-н дүгнэлт\Төсөл.Docx

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 13 зорилтын хүрээнд 61 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 93 хувьтай дүгнүүлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ӨСӨХБАЯР

F:\2.Бичиг хэрэг\2025он\СТА-н дүгнэлт\Төсөл.Docx

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,043,346,966.09** | **2,894,659,218.09** |
| **33** | **АВЛАГА** | 2,043,346,966.09 | 2,894,659,218.09 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 83,754,233.00 | - |
| **335** | **Бусад авлага** | 1,954,161,159.00 | 2,889,227,644.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 132,585,900.00 | - |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 1,821,575,259.00 | 2,889,227,644.00 |
| **336** | **Зээлийн авлага** | 5,431,574.09 | 5,431,574.09 |
| **3361** | **Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага** | 5,431,574.09 | 5,431,574.09 |
| 33612 | Хувь хүмүүст олгосон зээл | 5,431,574.09 | 5,431,574.09 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,043,346,966.09** | **2,894,659,218.09** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,043,346,966.09** | **2,894,659,218.09** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,043,346,966.09 | 2,894,659,218.09 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 2,043,346,966.09 | 2,894,659,218.09 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,413,587,714.09 | 1,910,761,066.09 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 629,759,252.00 | 983,898,152.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,043,346,966.09** | **2,894,659,218.09** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **3,456,277,617.66** | **5,003,727,159.26** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,780,420,117.66** | **2,322,605,659.26** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,780,420,117.66 | 2,322,605,659.26 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,780,420,117.66 | 2,322,605,659.26 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,780,420,117.66 | 2,322,605,659.26 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,675,857,500.00** | **2,681,121,500.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,675,857,500.00 | 2,681,121,500.00 |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | 1,675,857,500.00 | 2,681,121,500.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,959,104,265.66** | **4,019,829,007.26** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,959,104,265.66** | **4,019,829,007.26** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 69,349,800.00 | 121,100,569.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 69,349,800.00 | 121,100,569.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 69,349,800.00 | 121,100,569.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2,889,754,465.66 | 3,898,728,438.26 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 607,561,800.00 | 562,976,400.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 607,561,800.00 | 562,976,400.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 537,012,931.24 | 479,347,615.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 537,012,931.24 | 479,347,615.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1,212,016,839.42 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,212,016,839.42 | - |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 533,162,895.00 | 2,856,404,423.26 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 533,162,895.00 | 2,856,404,423.26 |

| | | | |
|---|---|---|---|
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **497,173,352.00** | **983,898,152.00** |
| 5 | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **497,173,352.00** | **983,898,152.00** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан* /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **3,465,796,617.66** | **5,087,481,392.26** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,780,420,117.66** | **2,406,359,892.26** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 1,780,420,117.66 | 2,406,359,892.26 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 1,780,420,117.66 | 2,406,359,892.26 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,780,420,117.66 | 2,322,605,659.26 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | - | 83,754,233.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,685,376,500.00** | **2,681,121,500.00** |
| 1310 | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,675,857,500.00 | 2,681,121,500.00 |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | 1,675,857,500.00 | 2,681,121,500.00 |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 9,519,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 9,519,000.00 | - |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **3,899,858,498.66** | **5,566,829,007.26** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,899,858,498.66** | **5,566,829,007.26** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **69,349,800.00** | **121,100,569.00** |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 69,349,800.00 | 121,100,569.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 69,349,800.00 | 121,100,569.00 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **3,830,508,698.66** | **5,445,728,438.26** |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,464,561,800.00 | 2,109,976,400.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 1,464,561,800.00 | 2,109,976,400.00 |
| 2133 | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 620,767,164.24 | 479,347,615.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 620,767,164.24 | 479,347,615.00 |
| 2134 | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1,212,016,839.42 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,212,016,839.42 | - |
| 2135 | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 533,162,895.00 | 2,856,404,423.26 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 533,162,895.00 | 2,856,404,423.26 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **(434,061,881.00)** | **(479,347,615.00)** |
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-** | **-** |
| 14 | **Бусад эх үүсвэр** | 434,061,881.00 | 479,347,615.00 |
| 145004 | Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх | 434,061,881.00 | 479,347,615.00 |
| 7 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **434,061,881.00** | **479,347,615.00** |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 434,061,881.00 | 479,347,615.00 |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|
| C01 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 2,043,346,966.09 | 2,043,346,966.09 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,043,346,966.09** | **2,043,346,966.09** |
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,043,346,966.09** | **2,043,346,966.09** |
| D01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **2,043,346,966.09** | **2,043,346,966.09** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | (132,585,900.00) | (132,585,900.00) |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,910,761,066.09** | **1,910,761,066.09** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 983,898,152.00 | 983,898,152.00 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,894,659,218.09** | **2,894,659,218.09** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

/төгрөгөөр/

| Хөтөлбөр, төслийн ангилал | | Төлөвлөгөө | | Гүйцэтгэл | |
|---|---|---|---|---|---|
| Код | Үзүүлэлт | Хүний тоо | Хөрөнгө | Хүний тоо | Хөрөнгө |
| 10 | Оны эхний үлдэгдэл | - | - | - | - |
| 101 | Харилцахын эхний үлдэгдэл | - | - | - | - |
| 102 | Кассын эхний үлдэгдэл | - | - | - | - |
| 11 | НЭГ. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН ОРЛОГО | - | 3,490,875,733.00 | 4,830 | 5,566,829,007.26 |
| 113 | ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлого | - | 726,000,000.00 | 3,372 | 2,322,605,659.26 |
| 116 | Өмнөх оны үлдэгдэл | - | 83,754,233.00 | - | 83,754,233.00 |
| 117 | ХЭД сангаас хуваарилсан санхүүжилт | - | 2,681,121,500.00 | - | 2,681,121,500.00 |
| 119 | Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт | - | - | 1,458 | 479,347,615.00 |
| 2 | ЗАРЦУУЛАЛТЫН ДҮН | 4,064 | 2,681,121,500.00 | 6,671 | 5,566,829,007.26 |
| 2 | ХОЁР. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ | 2,459 | 22,255,500.00 | 6,671 | 5,566,829,007.26 |
| 21 | 2.1 Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ | 1,146 | 14,110,000.00 | 770 | 14,110,000.00 |
| 211 | Ганцаарчилсан ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ | 376 | 5,640,000.00 | - | 5,640,000.00 |
| 212 | Бүлгээр ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ | 770 | 8,470,000.00 | 770 | 8,470,000.00 |
| 22 | 2.2 Ажилд зуучлах үйлчилгээ | 1,313 | 8,145,500.00 | 800 | 6,350,000.00 |
| 221 | Ажилд зуучлах үйлчилгээ | 500 | 3,500,000.00 | 500 | 3,500,000.00 |
| 222 | Хөдөлмөр эрхлэх чадавхын үнэлгээ | 300 | 2,850,000.00 | 300 | 2,850,000.00 |
| 224 | Хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөө боловсруулах | 513 | 1,795,500.00 | - | - |
| 3 | ГУРАВ. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ | 1,603 | 2,528,716,000.00 | 1,462 | 2,081,094,800.00 |
| 31 | 3.1 Хөдөлмөрт бэлтгэх сургалт | 697 | 44,815,000.00 | 687 | 40,330,000.00 |
| 311 | Суурь ур чадварын сургалт | 170 | 5,100,000.00 | 170 | 5,100,000.00 |
| 3111 | Суурь ур чадварын сургалт зохион байгуулах | 170 | 5,100,000.00 | 170 | 5,100,000.00 |
| 312 | Танхимын болон үйлдвэрлэл дээрх мэргэжлийн сургалт | 100 | 22,500,000.00 | 100 | 18,660,000.00 |
| 3121 | Танхимын сургалт зохион байгуулах | 50 | 12,000,000.00 | 50 | 12,000,000.00 |
| 3123 | Хоол унааны зардал | 50 | 10,500,000.00 | 50 | 6,660,000.00 |
| 313 | Аж ахуй эрхлэлтийн сургалт | 215 | 5,675,000.00 | 176 | 5,090,000.00 |
| 3131 | Аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах / жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгохоос өмнөх сургалт/ | 90 | 1,350,000.00 | 51 | 765,000.00 |
| 3132 | Аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах / жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгосны дараах сургалт/ | 45 | 1,125,000.00 | 45 | 1,125,000.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3133 | Мал маллах болон малын ашиг шим боловсруулах сургалт зохион байгуулах | 80 | 3,200,000.00 | 80 | 3,200,000.00 |
| 314 | Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний загвар төвд сургалт зохион байгуулах | 195 | 7,800,000.00 | 195 | 7,800,000.00 |
| 3141 | Сургалт, зөвлөгөө үйлчилгээг мэргэжлийн талуудтай хамтран зохион байгуулах | 75 | 3,000,000.00 | 75 | 3,000,000.00 |
| 3142 | Хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн эрхийг маргаан шийдвэрлэх зохицуулалт, хөдөлмөрийн харилцааны сургалтыг түр болон цагийн ажил хөдөлмөр эрхэлдэг оюутан залуучуудад зохион байгуулах | 120 | 4,800,000.00 | 120 | 4,800,000.00 |
| 315 | Эмэгтэйчүүдэд зориулсан богино хугацааны ур чадвар олгох болон гэрээс, зайнаас ажиллахыг дэмжих сургалт | 17 | 3,740,000.00 | 46 | 3,680,000.00 |
| 3151 | Мэргэжлийн болон цахим ур чадварыг богино хугацаанд эзэмшүүлэх хөдөлмөр эрхлэлтийн хосолсон сургалт | 17 | 3,740,000.00 | 46 | 3,680,000.00 |
| 32 | 3.2 Аж ахуй эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг | 241 | 1,874,056,000.00 | 93 | 1,522,600,000.00 |
| 321 | Иргэн, аж ахуйн нэгжид санхүүгийн дэмжлэг олгох | 35 | 350,000,000.00 | 43 | 350,000,000.00 |
| 3211 | Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох | 35 | 350,000,000.00 | 43 | 350,000,000.00 |
| 322 | Малчдыг малжуулах | 159 | 1,217,336,000.00 | - | 885,000,000.00 |
| 3221 | Малгүй болон цөөн малтай малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох | 150 | 1,200,000,000.00 | - | 885,000,000.00 |
| 3222 | Гэрээт малчин өрхийн гишүүдийн нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөх | 5 | 6,336,000.00 | - | - |
| 3223 | Гэрээт малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох | 2 | 10,000,000.00 | - | - |
| 3224 | Гэрээт малчин өрхийн орон нутаг руу нүүхэд олгох нэг удаагийн санхүүгийн дэмжлэг | 2 | 1,000,000.00 | - | - |
| 323 | Шилдэг Старт-Ап залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох | 2 | 18,000,000.00 | 1 | 18,000,000.00 |
| 3231 | Шилдэг Старт-Ап залуу, залуучуудын багт санхүүгийн дэмжлэг олгох | 1 | 10,000,000.00 | 1 | 10,000,000.00 |
| 3232 | Старт-Ап залуучуудад гарааны бизнесийн дэмжлэг үзүүлэх /Сургалт, зөвлөгөө, ментор/ | 1 | 8,000,000.00 | - | 8,000,000.00 |
| 324 | Ахмадын санхүүгийн дэмжлэг | 30 | 240,000,000.00 | 34 | 240,000,000.00 |
| 3241 | Санхүүгийн дэмжлэг олгох | 30 | 240,000,000.00 | 34 | 240,000,000.00 |
| 325 | Ажил олгогчийг дэмжих | 3 | 22,320,000.00 | 1 | 6,600,000.00 |
| 3251 | Ажил олгогчид урамшуулал олгох /6 сараас дээш хугацаагаар бүртгэлтэй ажилгүй иргэнийг ажлын байраар хангасан/ | 1 | 7,920,000.00 | 1 | 6,600,000.00 |
| 3252 | Ажил олгогчид санхүүгийн дэмжлэг олгох /асрамжийн газраас гарсан, хорих ангиас суллагдсан иргэнийг ажлын байраар хангасан/ | 2 | 14,400,000.00 | - | - |
| 326 | Түрээсийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ | 10 | 24,000,000.00 | 12 | 20,900,000.00 |
| 3261 | Түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх | 10 | 12,000,000.00 | 10 | 11,700,000.00 |
| 3262 | Борлуулалтын дэмжлэг үзүүлэх | - | 12,000,000.00 | 2 | 9,200,000.00 |
| 327 | Хүүхэд харах төвд түрээсийн болон бусад дэмжлэг үзүүлэх | 2 | 2,400,000.00 | 2 | 2,100,000.00 |
| 3271 | Хүүхэд харах төвд түрээсийн болон бусад дэмжлэг үзүүлэх | 2 | 2,400,000.00 | 2 | 2,100,000.00 |
| 33 | 3.3 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр | 199 | 168,845,000.00 | 133 | 162,809,200.00 |
| 332 | Санхүүгийн дэмжлэг | 169 | 147,755,000.00 | 89 | 145,450,000.00 |
| 3321 | Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох /50 хувь эргэн төлөлттэй/ | 18 | 144,000,000.00 | 27 | 144,000,000.00 |
| 3325 | Аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах /жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгохоос өмнөх сургалт/ | 85 | 1,445,000.00 | 36 | 540,000.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3326 | Аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах /жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгохоос дараах сургалт/ | 66 | 2,310,000.00 | 26 | 910,000.00 |
| 333 | Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн төлбөрт дэмжлэг үзүүлэх | 2 | 4,800,000.00 | 3 | 4,696,000.00 |
| 3331 | Борлуулалтын дэмжлэг үзүүлэх | - | 2,400,000.00 | 1 | 2,296,000.00 |
| 3332 | Түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх | 2 | 2,400,000.00 | 2 | 2,400,000.00 |
| 334 | Хөгжлийн бэрхшээлтэй хүнд ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх | 1 | 7,920,000.00 | 1 | 6,600,000.00 |
| 3341 | Ажил олгогчид урамшуулал олгох /ХБИ-ийг ажилд авч 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан ажил олгогч/ | 1 | 7,920,000.00 | 1 | 6,600,000.00 |
| 335 | Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах | 27 | 8,370,000.00 | 40 | 6,063,200.00 |
| 3351 | Танхимын сургалт зохион байгуулах | 12 | 3,744,000.00 | 20 | 3,640,000.00 |
| 3352 | Үйлдвэрлэл дээрх сургалт зохион байгуулах | 3 | 2,106,000.00 | - | - |
| 3353 | Хоол, унааны зардал | 12 | 2,520,000.00 | 20 | 2,423,200.00 |
| 34 | 3.4 Түр ажлын байрыг дэмжих арга хэмжээ | 456 | 222,040,000.00 | 549 | 220,615,600.00 |
| 341 | Мод тарих | 200 | 80,000,000.00 | 241 | 79,891,200.00 |
| 342 | Нийтийг хамарсан ажил зохион байгуулах | 200 | 80,000,000.00 | 253 | 79,764,400.00 |
| 343 | Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ | 55 | 59,400,000.00 | 54 | 58,320,000.00 |
| 3431 | Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ зохион байгуулах | 55 | 59,400,000.00 | 54 | 58,320,000.00 |
| 344 | Хүүхэд хамгаалагч үйлчилгээ | 1 | 2,640,000.00 | 1 | 2,640,000.00 |
| 35 | 3.5 Засгийн газар, ХЭҮЗ-ийн шийдвэрээр тодорхойлогдсон хөтөлбөр, төсөл | 10 | 218,960,000.00 | - | 134,740,000.00 |
| 351 | Засгийн газраас болон ХЭҮЗ-ийн шийдвэрээр батлан хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ | 10 | 218,960,000.00 | - | 134,740,000.00 |
| 3512 | Ажил олоход хүндрэлтэй иргэнийг тогтмол ажлын байраар хангасан аж ахуйн нэгжид санхүүгийн дэмжлэг үзүүлэх | - | 200,000,000.00 | - | 124,740,000.00 |
| 3513 | Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчдыг ажил олгогчид дагалдуулан суралцуулахад дэмжлэг үзүүлэх | 10 | 3,960,000.00 | - | - |
| 3516 | Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр | - | 10,000,000.00 | - | 10,000,000.00 |
| 3518 | Аймаг дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага бүс орон нутгийн онцлог хэрэгцээ шаардлагад тулгуурлан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлэх үйлчилгээ, арга хэмжээний санал боловсруулах | - | 5,000,000.00 | - | - |
| 4 | ДӨРӨВ. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА | 2 | 130,150,000.00 | 3,639 | 129,522,169.00 |
| 401 | Жижиг зээлийн хүүгийн хөнгөлөлт | 2 | - | - | - |
| 402 | Хөдөлмөрийн тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ болон ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн хэрэгжилтийг хангах | - | 10,000,000.00 | - | 9,399,300.00 |
| 403 | Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, мэдээллийн системийг сайжруулах, шинэчлэх | - | 9,000,000.00 | - | 8,994,198.00 |
| 404 | Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, ажилтнуудын чадавх бэхжүүлэх сургалт, зөвлөгөөн зохион байгуулах | - | 34,750,000.00 | 24 | 34,748,450.00 |
| 405 | Хөдөлмөр эрхлэлтийг сурталчлах, олон нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээ, хөдөлмөрийн яармаг, өдөрлөг зохион байгуулах, хууль тогтоомж, эрх зүйн актын уулзалт, хэлэлцүүлэг, зөвлөгөөн | - | 35,000,000.00 | 5 | 34,999,010.00 |
| 406 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд дүн шинжилгээ, хяналт, үнэлгээ хийлгэх | - | 28,000,000.00 | - | 27,981,211.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 408 | Гарын авлага, маягт, хэвлэмэл материалын эх бэлтгэх, хэвлүүлэх | - | 8,000,000.00 | 3,600 | 8,000,000.00 |
| 411 | Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих | - | 5,400,000.00 | 10 | 5,400,000.00 |
| 61 | ЗУРГАА. ТӨВЛӨРҮҮЛЭЛТ | - | - | - | 3,335,752,038.26 |
| 6110 | Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт - ХЭДСан | - | - | - | 479,347,615.00 |
| 6120 | ХБИ ажиллаагүй төлбөрийн орлого - ХЭДСан | - | - | - | 2,322,605,659.26 |
| 6130 | Санхүүжилтын буцаалт - ХЭДСан | - | - | - | 533,798,764.00 |
| 9 | Эцсийн үлдэгдэл | - | - | - | - |
| 91 | Харилцахын эцсийн үлдэгдэл | - | - | - | - |
| 92 | Кассын эцсийн үлдэгдэл | - | - | - | - |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

Аудитаар 12,250.0 мянган төгрөгийн 5 зөрчил[1] илэрсэнд зөвлөмж өгсөн.

### 3.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогүй.

### 3.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

*Илрүүлэлт-1:* Тайлант хугацаанд 12,250.0 мянган төгрөгийн дотоод албан томилолт олгохдоо томилолтын хуудсыг байгууллагын дарга бүрэн бөглөж, баталгаажуулаагүй, олгох хувь хэмжээг бөглөөгүй, удирдамж, мөнгө олгохыг хүссэн анхан шатны баримтыг хавсаргасан нь нотлогдохгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.6 "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д заасныг хэрэгжүүлэн анхан шатны баримтыг бүрэн бөглөж хэвших.

*Илрүүлэлт-2:* Бараа, үйлчилгээний худалдан авалтын төлбөрийн Е баримтын зардлыг барааны нэр төрөл, тоо ширхгээр гаргуулаагүй, бөөн дүнгээр шивүүлж, анхан шатны баримтад хавсарсан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-д "анхан шатны баримт бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу төлбөрийн баримтад үндэслэн хөтөлж, татварын тайланг санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэлд үндэслэн үйлдэх" гэж заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Бараа, үйлчилгээ худалдан авалт хийх тухай бүрд борлуулагчийн хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг кассын машинаас хэвлүүлэн авч анхан шатны баримтад хавсаргаж ажиллах.

*Илрүүлэлт-3:* Бараа материалын зарцуулалтын тайлан гаргахдаа батлагдсан маягт ашигладаггүй байна.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Сангийн сайдын 2016 оны 347 дугаар тушаал "Маягт заавар батлах тухай"-д гэж заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Сангийн сайдын 2016 оны 347 дугаар тушаал "Маягт заавар батлах тухай"-г хэрэгжүүлж хэвших.

*Илрүүлэлт-4:* Тайланд тусгасан авлагын үлдэгдэлд тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2 "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Авлагын үлдэгдэлд тооцоо нийлж баталгаажуулан ажиллах

*Илрүүлэлт-5:* Тус байгууллага нь тайлант оны эцсийн үлдэгдэлд 377,667.259 төгрөгийн насжилт өндөртэй авлагыг барагдуулах талаар ямар нэг арга хэмжээ авч ажилласан нь нотлогдохгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д"төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Насжилт өндөр авлагыг барагдуулах талаар ажил зохион байгуулан ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Д.д | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| | Дүн | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Д.д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| 1 | Тайлант хугацаанд 12,250,000 төгрөгийн дотоод албан томилолт олгохдоо томилолтын хуудсыг байгууллагын дарга бүрэн бөглөж, баталгаажуулаагүй, олгох хувь хэмжээг бөглөөгүй, удирдамж, мөнгө олгохыг хүссэн анхан шатны баримтыг хавсаргасан нь нотлогдохгүй байна. | 1 | 12,250.0 | | | | | 1 | 12,250.0 | | | | |
| 2 | Бараа, үйлчилгээний худалдан авалтын төлбөрийн Е баримтын зардлыг барааны нэр төрөл, тоо ширхгээр гаргуулаагүй, бөөн дүнгээр шивүүлж, анхан шатны баримтад хавсарсан байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| 3 | Бараа материалын зарцуулалтын тайлан гаргахдаа батлагдсан маягт ашигладаггүй байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| 4 | Тайланд тусгасан 2,894,659,218.09 төгрөгийн авлагын үлдэгдэлд тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | Тус байгууллага нь тайлант оны эцсийн үлдэгдэлд 377,667,259 төгрөгийн насжилт өндөртэй авлагыг барагдуулах талаар ямар нэг арга хэмжээ авч ажилласан нь нотлогдохгүй байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| | **Дүн** | **5** | **12,250.0** | **-** | **-** | **-** | **-** | **5** | **12,250.0** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Д.д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | | | | | | | | | |
| | **Дүн** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** |